



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 8 сарын 28 өдөр

Дугаар Б/31

Модот

Л.Ариунтунгалагийг ажилд эргүүлэн
томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47, 49 дүгээр зүйл, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэхь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогчийн албан тушаалд Лхамсүрэнгийн Ариунтунгалагийг 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Л.Ариунтунгалагийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ганчимэг	Нягтлан бодогч
Нарийн бичиг: О.Жавзмаа	Насан туршийн боловсролын багш
Гишүүд: Г.Золбоо	Нярав

3. Л.Ариунтунгалагийн сарын үндсэн цалин ТҮМ-7 зэрэглэлээр 1471000 /нэг сая дөрвөн зуун далан нэгэн мянга/ төгрөгөөр тооцож олгохыг ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Д.Ганчимэг)-т зөвшөөрсүгэй.

4.Өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагатай ёс зүйтэй, идэвхи санаачлагатай, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг (Л.Ариунтунгалаг)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ

My Documents /TUSHAAL/